

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН 2010 ОНЫ
ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,
2011-2012 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ**

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын 2010 оны төсвийн хүрээний мэдэгдэл,
2011-2012 оны төсвийн төсөөллийн тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу 2010 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2011-2012 оны төсвийн төсөөллийг төсвийн болон макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, дунд хугацааны бодлого, зорилтыг тодорхойлох замаар боловсруулав. Засгийн газрын дунд хугацааны зорилтууд, Засгийн газраас 2010 онд төлөвлөсөн төсвийн урсгал зардал болон орлогын хэмжээ, хөрөнгө оруулалт, төсвийн нийт болон урсгал тэнцэл, тэдгээрийн талаар дараагийн 2 жилд тавих зорилтыг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдтэй уялдуулан тодорхойллоо. Түүнчлэн дунд хугацааны бодлогын зорилтуудыг “МХЗ-уудад суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “ОУВС-гийн Захирлуудын зөвлөлөөр баталсан хөтөлбөр” болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдуулав.

Төсвийн хүрээний мэдэгдэлийн төсөлд тусгасан макро эдийн засгийн өсөлтийн тооцоо, нийгмийн халамж, гадаадын зээл тусламж, хөрөнгө оруулалт, бодит салбарын хөгжлийн зорилтуудыг олон улсын санхүү, эдийн засгийн өнөөгийн болон цаашдын төлөв байдал, гадаад худалдааны орчин огцом өөрчлөгдөж байгаа хандлага, эдгээрийн нөлөөллийг харгалзан шинэчлэн тодорхойлсон болно. Ийм учраас Төсвийн хүрээний энэ удаагийн мэдэгдлийн эдийн засгийн өсөлтийн тооцоо нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг 2009 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тодорхойлсон түвшнээс буурч гарахаар байна. Түүнчлэн бодлогын зарим зорилтыг нилээд онцлогтой, уян хатан хэрэгжүүлэхээр тодорхойлж байгаа юм.

Дунд хугацааны зорилтууд нь дэлхийн санхүүгийн хямралаас үүдэлтэй манай санхүү, эдийн засгийн салбарын хүндрэл, бэрхшээлийг даван туулахад гадаад, дотоод нөөц бололцоог дайчлан, эдийн засгийн цаашдын тогтвортой өсөлтийг хангах, үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлж, “Атрын 3 дахь аян”-ны хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэгдэж байна.

Дунд хугацаанд эдийн засгийн бодит өсөлт 7.0-9.0 хувь байхаар байна. Төсвийн нийт алдагдлын ДНБ-д эзлэх хувийг 2010 онд -4.0 хувь, дунд хугацааны эцэст -2.0 болгож бууруулахаар тооцлоо.

-----ooOoo-----

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны_сарын_өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төсвийн хүрээний мэдэгдлийг
зөвшөөрөх тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 6.1.2 дахь заалт, 25 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын 2010 оны төсвийн хүрээний мэдэгдлийн болон 2011-2012 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтүүдийг 1 дүгээр хавсралтаар, Засгийн газрын дунд хугацааны зорилтуудыг 2 дугаар хавсралтаар тус тус зөвшөөрсүгэй.

2.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2010 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулийн төслийг энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвшөөрсөн үзүүлэлтүүдийг баримтлан боловсруулахыг Монгол Улсын Засгийн газар /С.Баяр/-т даалгасугай.

3. МонголУлсын 2010 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэж батлахдаа энэ тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвшөөрсөн үзүүлэлтүүдийг баримталж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/, Төсвийн байнгын хороо /Ч.Хүрэлбаатар/-нд даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

Монгол Улсын Их Хурлын 2009 оны
.... дугаар сарын ...-ны өдрийн дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН 2010 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ
МЭДЭГДЛИЙН БОЛОН 2011-2012 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨӨЛЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	Эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Төсөөлөл		
		2010 он	2011 он	2012 он
1.	ДНБ-ий бодит өсөлтийн хэмжээ, хувь	7.0	8.2	9.0
	ДНБ-д эзлэх хувиар			
2	Төсвийн нийт орлогын доод хэмжээ	31.6	28.0	27.0
3	Төсвийн нийт зарлагын дээд хэмжээ	35.6	31.0	29.0
4	Төсвийн урсгал тэнцлийн доод хэмжээ	2.6	3.6	4.6
5	Төсвийн алдагдлын дээд хэмжээ	-4.0	-3.0	-2.0
6	Хөрөнгийн зардлын доод хэмжээ	5.8	4.5	4.7

Монгол Улсын Их Хурлын 2009 оны
..... дугаар сарын-ны өдрийндүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2010-2012 ОНЫ ДУНД ХУГАЦААНЫ ЗОРИЛТУУД

Засгийн газрын дунд хугацааны зорилт нь хөгжлийн тэргүүлэх ач холбогдолтой салбаруудын үйл ажиллагааг өргөжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, уул уурхайн болон нэмүү өртөг шингэсэн боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж, үйлдвэржилтийн бодлогыг хэрэгжүүлэх, төрийн удирдлагын ил тод, шуурхай, шударга, хариуцлагатай байдлыг хангах, ард түмний амьжиргааны түвшинг дээшлүүлж, ядуурал, ажилгүйдлийг бууруулахад чиглэгдэнэ.

Нэг. Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангана.

1.1. Стратегийн болон бусад ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хувийн хэвшил, бодит салбарын үйлдвэрлэлийг дэмжих замаар дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг хангах;

1.2. Эдийн засгийн бүтцийг сайжруулж, дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах аж үйлдвэр, үйлчилгээний салбарын эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх бодлого баримтлах;

1.3. Инфляцийг бууруулах, төсөв, мөнгө, санхүү, эдийн засгийн харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлэх;

1.4. Санхүү, эдийн засгийн хямралт байдлыг даван туулах цогц арга хэмжээ авч, түүний дараах эдийн засгийн сэргэлтийг дэмжиж, нийт эдийн засаг дахь Засгийн газрын оролцоог багасгах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийн эрүүл хөрс, суурийг бэхжүүлэх;

1.5. Төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдлыг багасгах бодлого баримталж, гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэх.

Хоёр. Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг хадгална.

2.1 Эдийн засгийн өсөлтийг хангах, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг бататгах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг хөгжлийн тэргүүлэх чиглэлд оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, бодит салбарын хөгжлийг тэтгэхэд чиглэсэн төсөв, мөнгөний бодлого явуулах;

2.2 ДНБ-д эзлэх төсвийн орлого, зарлагын харьцааг огцом алдагдуулалгүйгээр тогтвортой түвшинд байлгах чиглэл баримталж, төсвийн алдагдлыг 2009 оны түвшнээс өсгөхгүйгээр аажмаар бууруулах;

2.3 Төсвийн орлогын бололцоотой бүх эх үүсвэрийг бүрэн дайчилж, оновчтой хувиарлан үр өгөөжтэй ашиглах;

2.4 Төсвийн зарлагын хэмжээг орлогын тогтвортой эх үүсвэр болон эдийн засгийн өсөлттэй уялдуулж, аливаа үргүй зардлыг хязгаарлан, төсвийн зарлагыг суурь хэмжээнд нь хүртэл бууруулах эхний алхам хийх;

2.5 Улсын төсвөөс үзүүлж буй нийтийг хамарсан нийгмийн халамжийн үйлчилгээ, дэмжлэгийн үндсэн зорилгыг хадгалж, түүнийг нийгмийн зорилтот бүлгүүд болон нийгмийн халамж хүртэх шаардлагатай хэсэгт чиглүүлж, үр дүнтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;

2.6 Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг санхүүгийн хямралт байдлыг даван туулахад гол түлхэц үзүүлэх, богино хугацаанд үр дүнгээ өгөх хөгжлийн томоохон төсөл, арга хэмжээнд чиглүүлэх;

2.7 Дотоод, гадаадын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжиж, санхүүжилтийн үр дүнг сайжруулах;

2.8 Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын зарим ордыг эдийн засгийн эргэлтэнд оруулж, уул уурхайн салбараас улсын төсөвт тогтвортой өндөр орлого орох урт хугацааны үндсийг бүрдүүлэх;

2.9 Эдийн засгийн өсөлт, мөнгө, санхүүгийн бодлогын уялдааг хангаж, гадаад валютын цэвэр албан нөөцийг нэмэгдүүлэн санхүүгийн хүндрэлийг даван туулах мөнгөн хуримтлалыг өсгөх;

2.10 Монгол Улсын зээлжих зэрэглэл буурч болзошгүй байгаа сөрөг хандлагыг зогсоож, улмаар зэрэглэлийг ахиулах эдийн засаг, санхүүгийн цогц арга хэмжээ авч эхлэх;

2.11 Санхүүгийн салбарыг эрсдэлээс хамгаалж, хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх;

2.12 Олон улсын санхүүгийн зах зээлд бонд арилжаалж, бондын эрсдлийг удирдан, Монгол Улсын жишиг хүүг тогтоох чиглэл баримтлах;

2.13 Татварын тэгш, шударга байх зарчмыг тууштай баримталж, татварын орлогын баазыг өргөтгөн, орлогыг бүрэн хураах удирдлага, бүртгэл, тооцоо, мэдээллийн тогтолцоог сайжруулах;

2.14 Төсөв, санхүүгийн хямралт байдлыг дэс дараатай даван туулах шаардлагатай уялдуулан эдийн засагт өрийн дарамт учруулахгүйгээр гадаад орон, олон улсын байгууллагаас авах зээлийн хэмжээг уян хатан нэмэгдүүлж, зээл тусламжийн хөрөнгийг үр өгөөжтэй ашиглах хяналт зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх;

2.15 Санхүүгийн зуучлалын хүрээг өргөтгөн, нягтлан бодох бүртгэл, аудит, хөрөнгийн бүртгэл, мэдээлэл, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2.16 Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчныг олон улсын санхүүгийн зах зээлийн нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгож, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх .

Гурав. Бодит салбарын хөгжлийг дэмжиж, Монгол Улсыг үйлдвэржүүлэх бодлого баримтална.

3.1. Уул уурхайн болон газрын тосны салбарын орлогоос хуримтлал бий болгож, улсын төсвийн тусгай санд төвлөрүүлэн, мэдлэгт суурилсан эдийн засаг, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эдийн засгийн бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

3.2. Эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг дэмжиж, сүү, мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах чиглэлд дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, экологийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;

3.3. Бүс нутгийн дэд бүтцийн хөгжилтэй уялдуулан автозам, төмөр замын сүлжээг хөгжүүлэх бодлого баримтлах;

3.4. Түүхий эдийн нөөцөд түшиглэн цемент, арматур төмөр хийц, шил зэрэг барилгын материалын хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжийг бүрдүүлж эхлэх;

3.5. Түлш, эрчим хүчний салбарын найдвартай ажиллагаа, аюулгүй байдлыг дээшлүүлэх, төр-хувийн хэвшлийн түншлэлийг дэмжих бодлого хэрэгжүүлэх;

3.6 Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжиж, бизнес инкубатор байгуулж ажиллуулах;

3.7 Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн, “Атрын 3 дахь аян”-ыг үргэлжлүүлж, техник, технологийн шинэчлэл хийх шаталсан арга хэмжээ авах;

3.8 Өндөр технологи, өрсөлдөх чадвар бүхий хувийн хэвшилд түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх, эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдүүлэх, экспортын үйлдвэрлэлийг татварын болон урамшууллын бодлогоор дэмжин хөгжүүлэх;

3.9 Бизнес эрхлэх орчныг сайжруулж, орон нутгийн түүхий эд, боломж, нөөцөд тулгуурласан үйлдвэрлэлийг хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн экспортын болон импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих замаар эдийн засгийн төрөлжилтийг сайжруулах;

3.10 Хүнд үйлдвэрийг хөгжүүлж, гидрометаллурги, катодын зэсийн үйлдвэрлэл, алт хайлуулах, кокс-хими, хар металлургийн аж үйлдвэрийн цогцолбор барьж байгуулахыг бодлогоор дэмжих;

3.11 Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах ажлыг эхлэх, газрын тосны бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангаж эхлэх бодлого баримтлах;

3.12 Говийн /Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр/ бүс нутгийг цогц хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, Тавантолгой, Оюутолгой, Цагаансуваргын ордод түшиглүүлэн уул уурхай-металлурги-эрчим хүчний цогцолборыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх;

3.13 Эрчим хүчний төрөл бүрийн эх үүсгүүрийг ашиглан нийт сумыг байнгын цахилгаантай болгох бодлого баримтлах;

3.14 Худалдаа, эдийн засгийн чөлөөт бүсүүдийг байгуулах бодлогыг шинэчилж, эдийн засгийн үйл ажиллагааг эрчимжүүлэх;

3.15 Шуудангийн салбарт Зип кодыг улс орны хэмжээнд бүрэн нэвтрүүлэх;

Дөрөв. Байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай уул уурхайг хөхиүлэн дэмжинэ.

4.1 Геологи, уул уурхайн салбарын бодлогыг хариуцлагатай уул уурхайн зарчимд тулгуурлан шинэчлэн тодорхойлж, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

4.2 Экологийн хувьд эмзэг, хамгаалалт шаардагдах ойн болон гол, мөрний эх, сав газраас бусад бүс нутгуудад ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааг нэгдсэн бодлогоор зохицуулах;

4.3 Уул уурхайн үйлдвэрлэлийн явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээх эрх зүйн орчинг сайжруулж, нөхөн сэргээлтийн чанарыг дээшлүүлэх иж бүрэн механизмыг бий болгох;

4.4 Хот суурин газарт цэцэрлэгт хүрээлэн, ногоон бүс байгуулах ажлыг бодлогоор дэмжих;

Тав. Иргэдээ эрүүл чийрэг, боловсролтой, ажил, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр ажиллана.

5.1 Хүн амыг эрүүл, аюулгүй, тэжээллэг хүнсээр жигд, хүртээмжтэй хангах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, “Эрүүл эхээс эрүүл хүүхэд” зарчмыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний бүх шатанд хэрэгжүүлж, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг тууштай бууруулах;

5.2 Шинэ болон дахин сэргэх халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлж, түүнийг аймаг, дүүргийн түвшинд өргөжүүлэх;

5.3 Бүх нийтийн боловсролыг хөгжүүлж, үндэсний боловсролыг олон улсын түвшинд ойртуулах, оюунжсан, бүтээлч, чадамжтай, эрүүл чийрэг хүний нөөцийг байнга нэмэгдүүлэх;

5.4 Хувилбарт сургалтын төрөл, хэлбэрийг олшруулж сайжруулах замаар сургуулийн өмнөх боловсролын сургалтын хамрах түвшинг дээшлүүлэх;

5.5 Зах зээлийн өнөөгийн эрэлт шаардлагад нийцсэн мэргэжлийн боловсролын сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.6 Ажлын байр, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх хүрээнд, иргэдийн идэвх, санаачилгыг дэмжин, хүн бүрийг эдийн засгийн идэвхтэй, хөдөлмөрийн чадвартай байлгахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж, ажилгүйдлийн түвшинг 2010-2012 онд 2.7- 2.5 хувьд хүргэж бууруулах;

5.7 Малчдын хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох, аж ахуйгаа тогтвортой эрхлэх, өргөжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засаг, нийгмийн үйлчилгээг өргөжүүлж, албан секторт шилжихэд нь дэмжлэг үзүүлэх;

5.8 Тэтгэврийн даатгалын сангийн менежментийг боловсронгуй болгон зах зээлийн жишигт нийцүүлэн хөгжүүлэх;

5.9 Малчин, албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах асуудлыг судлан шийдвэрлэх;

5.10 Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх.

Зургаа. Төрийн үйлчилгээний чанар, үр дүнг сайжруулна.

6.1 Төрийн удирдлагын ил тод, цомхон, чадварлаг, шуурхай байдлыг хангаж, төр, иргэний хамтын ажиллагаа, харилцан итгэлцлийг бэхжүүлэх;

6.2 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн удирдлага, зохион байгуулалт, бүтцийг боловсронгуй болгох, орон нутгийн бие даасан байдлыг хангах;

6.3 Төсөвт байгууллагуудын ажил үйлчилгээний чанар, хүртээмжид төрийн бус байгууллагууд, олон нийт, иргэдийн зүгээс тавих хяналтын тогтолцоог сайжруулах;

6.4 Төрийн байгууллагын бүтцийг боловсронгуй болгож, төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

-----ooOoo-----

ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЛИЙН ТАЛААРХИ ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газар Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд заасан төсвийн удирдлагын зарчмыг үндэс болгон Монгол Улсын 2010 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2011-2012 оны төсвийн төсөөллийг боловсрууллаа. Үүнд:

1. Монгол Улсын 2010 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2011-2012 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан макро эдийн засаг, төсвийн үзүүлэлтүүдийг ОУВС-тай тохирсон хөтөлбөрийн үзүүлэлтүүдтэй нийцүүлэх чиглэл баримтлав.
2. Монгол Улсын 2010-2012 оны Төсвийн хүрээний мэдэгдэлд хөрөнгө оруулалтын хэмжээг эдийн засгийн шингээх чадвартай уялдуулан, харьцангуй богино хугацаанд өндөр үр өгөөж өгөх хөгжлийн томоохон төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, эдийн засаг, үндэсний хуримтлалын чадавхийг нэмэгдүүлэх шаардагатай холбон тодорхойлов.
3. Төсвийн орлогыг бүрдүүлэх нөөц бололцоог дайчлах, эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилтуудыг хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд орлогын бодлого чиглэгдэв.
4. Зарлага, санхүүжилтийг цаг хугацаанд нь оновчтой зохион байгуулж, дунд хугацаанд төсвийн нийт тэнцлийн алдагдал зохистой түвшинд буюу ОУВС-тай тохирсон хөтөлбөрт тусгагдсан үзүүлэлттэй нийцтэй байх бодлого баримталсан.
5. Дунд хугацаанд төсвийн алдагдлыг 2009 оны түвшин/-6 хувь/-нээс өсгөхгүйгээр аажмаар багасган, 2012 оны эцэст ДНБ-ний -2 хувьд байхаар тооцоолов.
6. Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлтийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хэмжээнд буюу нэг оронтой тоонд байлгах зорилт тавьсан.
7. Санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах цогц арга хэмжээ авч, түүний дараах эдийн засгийн сэргэлтийг дэмжин, цаашдын хөгжлийн нөөц, чадавхийг бодитой үнэлж, эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд 7 хувиас доош бууруулахгүй байлгах зорилт тавилаа.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН 2010 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2011-2012 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТООЦООНЫ ТАНИЛЦУУЛГА

Нэг. Монгол Улсын эдийн засаг, нийгмийн байдал 2008-2009 онд

1.1 Эдийн засгийн гадаад орчин

Зураг 1. Дэлхийн эдийн засгийн өсөлт




Дэлхий нийтийг хамарсан санхүүгийн хямралаас улбаалан дэлхийн эдийн засгийн өсөлт 2008 онд 2007 оныхоос 1.8 пунктээр буурч 2008 онд 3.4 хувь болсон байна. АНУ-ын эдийн засгийн өсөлт 2007 онд 2.0 хувь байснаа 2008 онд буурч 1.1 хувьд хүрчээ. Уг бууралтад санхүүгийн хямрал, ам.долларын ханшны сулралт болон бараа бүтээгдэхүүний эрэлт, хэрэгцээ багассан зэрэг нь нөлөөлжээ.

Эх сурвалж: ОУВС, World economic outlook

Японы эдийн засаг 2008 онд 0.3 хувиар буурсан байна. Автомашин, техник, технологийн бараа бүтээгдэхүүний экспортын борлуулалт буурсан нь Японы эдийн засгийн өсөлтийг бууруулах үндсэн шалтгаан болжээ. Харин БНХАУ-ын эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр хэвээр байлаа. БНХАУ-ын эдийн засаг 2008 онд 9.0 хувиар өсөв. ОХУ-ын эдийн засгийн өсөлтийн хурдац өмнөх оноос бага зэрэг саарч 2008 онд 6.2 хувь болов.

Зураг 2. Инфляцийн түвшин


Инфляцийн түвшин 2007 онд хөгжиж буй орнуудад дунджаар 6.4 хувь байсан бол 2008 онд 9.2 хувьд хүрлээ. Үүний гол шалтгаан нь 2007 оны дөрөвдүгээр улирал, 2008 оны эхэн үеэс дэлхийн зах зээл дээр гурил, улаанбуудай, цагаан будаа болон газрын тосны үнэ огцом өсч эхэлсэн юм. Дээрх үнийн өсөлт хөгжингүй оронд мөн нөлөөлөв. Тухайлбал 2007 онд хөгжингүй орнуудад хэрэглээний үнийн индекс 2.1 хувь байсан бол 2008 онд



Эх сурвалж: ОУВС, World economic outlook

3.5 хувь болж өссөн байна. Гэхдээ 2008 оны сүүлийн хагасаас эхэлж санхүү, эдийн засгийн хямралаас үүдэн хэрэглээ огцом унаснаас шалтгаалж газрын тос, улаанбуудай болон цагаан будааны үнэ буурлаа. Цагаан будаа, улаанбуудайн үнийн бууралтанд дэлхийн үр тарианы ургац нэмэгдэж нийлүүлэлт өссөн нь мөн нөлөөлжээ. Манай хөрш орон ОХУ-д 2007 онд инфляцийн түвшин 11.9 хувь, 2008 онд 13.3 хувьд хүрсэн бол БНХАУ-ын инфляцийн түвшин 2007 онд 4.8 хувь, 2008 онд 5.9 хувьд хүрсэн байна.


Зураг 3. Газрын тосны дэлхийн зах зээлийн үнэ, ам.доллараар



Өнгөрсөн онд газрын тосны үнэ дэлхийн зах зээл дээр өссөөр 2008 оны 7 дугаар сард 147 ам.доллар буюу оргил цэгтээ хүрчээ. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын улмаас газрын тосны эрэлт буурахын зэрэгцээ ОПЕК-ийн орнуудын нийлүүлэлтийн хэмжээ харьцангуй өндөр байсан нь үнэ буурах гол шалтгаан болж 2008 оны 12 дугаар сард нэг баррель нь 36 ам.долларт хүрч буурсан байна.

Зэсийн дэлхийн зах зээлийн дундаж үнэ 2007 онд 7116.4 ам.доллар байсан бол аажмаар өсч 2008 оны 4 дүгээр сард 8683 ам.долларт хүрчээ. Харин энэ оны 10 дугаар сараас эхлэн буурч оны эцэст 3000 ам.долларт хүрсэн байна.

Зураг 4. Зэсийн дэлхийн зах зээлийн үнэ




1.2 Эдийн засгийн өсөлт, ДНБ-ий хэмжээ

2008 оны урьдчилсан гүйцэтгэлээр хөдөө аж ахуйн салбар 5.0 хувь, боловсруулах үйлдвэр 4.7 хувь, тээвэр холбоо 19.5 хувь, үйлчилгээний салбар 15.9 хувь өсч, ДНБ зэрэгцүүлэх үнээр 3620.5 тэрбум төгрөгт хүрч, эдийн засгийн бодит өсөлт 8.9 хувь боллоо. 2008 оны эхний гурван улиралд гадаад, дотоод хүчин зүйлсийн нөлөөгөөр хэрэглээний үнийн өсөлт харьцангуй өндөр байснаас ДНБ-ий дефляторын өөрчлөлт 22.4 хувьд хүрч, ДНБ-ий хэмжээ оны үнээр 6130.3 тэрбум төгрөгт хүрчээ.

Зураг 5. Эдийн засгийн өсөлт, нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ

2008 оны ДНБ-ий 8.9 хувийн өсөлтөд малын тоо толгой 43.3 саяд хүрсэн, газар тариалангийн салбарын үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад 21.0 хувиар өссөн, түүнчлэн үйлчилгээний салбар 15.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.




Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтөд гол хувь нэмэр оруулсан салбарууд

2009 суурь хувилбар		2009 Зорилтот хувилбар	
Салбар	Оруулсан хувь нэмэр	Салбар	Оруулсан хувь нэмэр
Нийт бодит өсөлт	-3.2	Нийт бодит өсөлт	3.1
<u>Хөдөө аж ахуй</u>	<u>0.2</u>	<u>Хөдөө аж ахуй</u>	<u>0.7</u>
Мал аж ахуй	0.20	Мал аж ахуй	0.20
Газар тариалан	0.04	Газар тариалан	0.46
<u>Үйлдвэрлэл</u>	<u>-1.5</u>	<u>Үйлдвэрлэл</u>	<u>0.9</u>
Боловсруулах үйлдвэр	-0.63	Уул уурхай, олборлох үйлдвэрлэл	0.72
Уул уурхай, олборлох үйлдвэр	-0.49	Боловсруулах үйлдвэр	0.10
		Цахилгаан, дулааны үйлдвэрлэл, усан хангамж	0.04
Барилга	-0.34	<u>Үйлчилгээ</u>	<u>1.6</u>
<u>Үйлчилгээ</u>	<u>-1.9</u>	<u>Үйлчилгээ</u>	<u>1.6</u>
Бөөний болон жижиглэн худалдаа	-0.28	Бөөний болон жижиглэн худалдаа	0.09
Тээвэр, агуулах, холбоо	-0.84	Тээвэр, агуулах, холбоо	0.97
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн үйл ажиллагаа	-0.34	Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	0.24


1.3 Улсын нэгдсэн төсөв

Зураг 6. Төсвийн орлого, түүний ДНБ-д эзлэх хувь

Улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн дүн 2008 оны эцэст 2170.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 35.4 хувьд хүрчээ. Харин 2009 оны төсвийн тодотголоор улсын нэгдсэн төсвийн орлого, тусламжийн дүн 2009 онд 1,973.01 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр болж ДНБ-ий 31.3 хувьд батлагдлаа.




Зураг 7. Төсвийн зарлага, түүний ДНБ-д эзлэх хувь



Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2008 оны эцэст 2466.8 тэрбум төгрөгт хүрсэн нь ДНБ-ий 40.2 хувьтай тэнцэж байна. 2009 онд улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2,314.2 тэрбум төгрөг болж ДНБ-ий 36.6 хувь байна.

Зураг 8. Нэгдсэн төсвийн тэнцэл, ДНБ-д эзлэх хувь

Монгол Улсын нэгдсэн төсөв сүүлийн 3 жил эерэг үзүүлэлттэй гарч байсан бол 2008 оны сүүлийн улирлаас эхлэн дэлхийн зах зээл дээр алт, зэсийн үнийн огцом уналтаас шалтгаалан төсвийн орлогын бүрдүүлэлт саарч улмаар эдийн засгийн хүндрэлээс үүдэн 2008 оны нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 389.8 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 296.4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарснаар төсвийн урсгал тэнцлийн ашиг ДНБ-ий 6.3 хувь, нийт тэнцлийн алдагдал ДНБ-ий 5.0 хувьтай тэнцэж байна. 2009 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 160.8 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 341.2 тэрбум төгрөгийн алдагдалтай гарахаар батлагдсан нь ДНБ-ий 2.6 хувь, нийт тэнцэл ДНБ-ий -5.4 хувьтай гарахаар байна.




1.4 Мөнгөний нийлүүлэлт, үнэ, ханш

Зураг 9. Мөнгөний нийлүүлэлт, тэрбум төгрөг

Мөнгөний нийлүүлэлт. Монгол банк заавал байлгах нөөцийн нормыг нэмэгдүүлэх, суурь хүүг өсгөх зэргээр мөнгөний бодлогыг чангатгасны улмаас 2008 оны эцэст мөнгөний нийлүүлэлт 2007 оныхоос 3.4 хувиар буурч 2318.9 тэрбум төгрөгт хүрлээ.


2009 оны эцэст мөнгөний нийлүүлэлтийг 25.0 орчим хувиар өснө гэж тооцлоо.



Үнийн өсөлт, ханшны өөрчлөлт

2008 онд гадаад зах зээл дээр улаан буудайн үнэ, хүнсний зарим бүтээгдэхүүний үнэ, газрын тос, нефть бүтээгдэхүүний үнэ өссөн зэргээс шалтгаалж хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өсч жилийн дундаж инфляцийн түвшин 28.0 хувь гарлаа. Гэвч 2008 оны дөрөвдүгээр улиралд бараа, үйлчилгээний бага зэрэг буурч улмаар үнийн ерөнхий түвшин оны эцэст 22.1 хувиар өссөн

Зураг 10. Инфляцийн түвшин, хөрш орнууд, хувь



байна. 2009 онд инфляцийн түвшин нэг оронтой тоонд байхаар байна.

Зураг 11. Зарим гадаад валютын ханш, төгрөгөөр



2008 онд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш харьцангуй тогтвортой, өөрчлөлт бага байсан хэдий ч оны сүүлчээр гадаад валютын нөөц 2007 онтой харьцуулахад 360 гаруй тэрбумаар буурсан, иргэд байгууллагын валютын нөөц багассан зэргээс шалтгаалан ам.долларын ханш огцом нэмэгдэж жилийн эцэст 1268 төгрөгт хүрсэн байна. 2009 оны хоёрдугаар сарын эцэст төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1471.45 төгрөгт хүрч өмнөх сарынхаас 6.5

хувиар сулраад байна. ОУВС, хандивлагч орнуудын зээл, тусламж орж ирснээр гадаад валютын нөөц нэмэгдэж улмаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш оны эцэст чангарах төлөвтэй байгаа тул 2009 оны эцэст төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1300 төгрөгт хүрэхээр байна.

1.5 Гадаад худалдаа

Монгол Улс 2008 онд дэлхийн 112 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 2007 оныхоос 1769.7 сая ам.доллар буюу 44.1 хувиар өсч, 5779.1 сая ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 710.1 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

2008 онд гадаад худалдааны тэнцэл ийнхүү алдагдалтай гарсан нь импортын хурдацтай өсөлттэй холбоотой байв.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2009 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4968.9 сая ам.доллар болж, 2008 оныхоос 810.0 сая ам.доллар буюу 16.3 хувиар буурахаар байна. Гадаад худалдаа 560.5 сая ам.долларын алдагдалтай гарахаар байна.

Экспорт. Экспортын хэмжээ 2008 онд 2534.5 сая ам.долларт хүрч өнгөрсөн оныхоос 587.0 сая ам.доллараар буюу 30.1 хувиар нэмэгдсэн байна. Экспортын хэмжээ 2009 онд 2204.2 сая ам.доллар болж, 2008 оныхоос 13.0 хувиар буюу 330.3 сая ам.доллараар буурахаар байна. Нийт экспортын барааны 57.5 хувийг эрдэс бүтээгдэхүүний экспорт дангаараа бүрдүүлж байгаагаас 34.9 хувийг зэсийн баяжмалын экспорт эзэлж байна. Манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал, алтны дэлхийн зах зээлийн үнэ буурсан нь экспортын орлогыг бууруулахад голлон нөлөөлөв.

Импорт. 2008 онд импортоор нийт 3244.5 сая ам.долларын бараа оруулсан нь 2007 оныхоос 1182.7 сая ам.доллараар буюу 57.4 хувиар өссөн байна. Импортын барааны бүтцийг авч үзвэл эрдэс бүтээгдэхүүн 361.2 сая ам. доллар буюу 60.1 хувиар; авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 235.8 сая ам. доллар буюу 105.6 хувиар, машин, механик тоног төхөөрөмж, тэдгээрийн эд анги 182.0 сая ам.доллар буюу 43.1 хувиар; үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүний импорт 103.2 сая ам.доллар буюу 62.7 хувиар тус тус өссөн нь импортын өсөлтөд голлон нөлөөлсөн байна.

Зураг 12. Гадаад худалдаа, сая ам.доллар



Импортын хэмжээ 2009 онд 2764.7 сая ам.долларт хүрч, 2008 оныхоос 14.8 хувиар буюу 479.9 сая ам.доллараар буурахаар байна.

1.6 Төлбөрийн тэнцэл

Монгол улсын төлбөрийн тэнцлийн урсгал данс 2008 онд урьдчилсан байдлаар 737.0 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 918.0 сая ам.долларын ашигтай гарснаар нийт төлбөрийн тэнцэл 338.1 сая ам.долларын алдагдалтай гарлаа. 2009 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт төлбөрийн тэнцэл 49.9 сая ам.долларын алдагдалтай гарахаар байгаа нь урсгал данс албан ёсны шилжүүлгийг оролцуулаад 524.8 сая ам.долларын алдагдалтай, хөрөнгө ба санхүүгийн данс 474.9 сая ам.долларын ашигтай гарахаар байна.

Урсгал данс. Сүүлийн жилүүдэд ашигтай гарч байсан урсгал данс 2008 онд алдагдалтай гарсан нь гадаад худалдааны алдагдал ихэсч, үйлчилгээний зардал өсч, бусад төлөх ногдол ашгийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой.

Цэвэр орлого. Эрдэнэт, Мобиком зэрэг гадаадын хөрөнгө оруулалттай томоохон аж ахуйн нэгжүүдээс гадаадын хөрөнгө оруулагчдад шилжүүлсэн ногдол ашгийн хэмжээ 2008 онд 103.4 сая ам.доллар болсон нь цэвэр орлогын данс 129.3 сая ам.долларын алдагдалтай гарахад голлон нөлөөлсөн байна.

Урсгал шилжүүлэг. Гадаадад ажиллаж байгаа Монгол иргэдийн гуйвуулсан мөнгөний хэмжээ 23 хувиар өсч 214.8 сая ам.долларт хүрсэн бөгөөд гадагш гуйвуулсан хэмжээ 27 хувиар өсч 114.8 сая ам.доллар болсон байна.

Хүснэгт 2. Гадаад валютын гуйвуулга /сая ам.доллар/

Үзүүлэлт	2004	2005	2006	2007	2008
/сая ам.доллараар/					
Хүлээн авсан	195.4	174.2	153.6	174.2	214.8
Шилжүүлсэн	49.1	40.4	76.5	90.3	114.8
Ажилчдын гуйвуулга	146.3	133.8	77.1	83.9	100.0

Санхүүгийн данс. Сүүлийн жилүүдэд барилга болон ашигт малтмал, уул уурхайн салбарт оруулах гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ эрс нэмэгдэж байгаа нь санхүүгийн данс 2.8


дахин нэмэгдэж, 918.0 сая ам.долларын ашигтай гарахад нөлөөлжээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/.

Зураг 13. Гадаадын шууд хөрөнгө оруулалт, улс орноор, салбараар

ГШХО-ын хэмжээ 2008 онд цэвэр дүнгээр 1.9 дахин нэмэгдэж 682.5 сая ам.долларт хүрчээ.

ГШХО-ын нийт хэмжээний 48 хувийг уул уурхайн салбарт, 13 хувийг барилгын салбарт оруулсан байна. Харин улс орноор нь авч үзвэл нийт ГШХО-ын 26 хувийг БНХАУ-аас оруулжээ.




1.7 Гадаад валютын цэвэр албан нөөц

Монгол Улсын гадаад валютын цэвэр албан нөөцийн хэмжээ 2007 онд 975.3 сая ам.долларт хүрч импортын 24.0 долоо хоногийн хэрэгцээг хангахуйц хэмжээтэй байсан бол 2008 онд 637.2 сая ам.доллар болж буурлаа.


Зураг 14. Гадаад валютын цэвэр албан нөөц /сая ам.доллар/, импортын долоо хоног

Энэ нь манай улсын импортын 10.2 долоо хоног буюу 2.4 сарын хэрэгцээг хангахуйц хэмжээнд байна.



Хоёр. Монгол Улсын макро эдийн засаг, санхүүгийн 2010-2012 оны хандлага

Зураг 15. Эдийн засгийн өсөлт, хувилбар /хувь/




Эдийн засгийн өсөлт. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралаас үүдэлтэй манай улсад учраад буй санхүү, эдийн засгийн хүндрэлтэй уялдаад эдийн засгийн нөхцөл байдал нилээд хувьсгамтгай байна. Иймээс 2009-2012 оны эдийн засгийн өсөлтийг үндсэн хоёр хувилбараар тооцож ОУВС-ын төсөөлөлтэй харьцуулан авч үзлээ. **Нэгдүгээр хувилбар:** Өнөөгийн санхүү,

эдийн засгийн хямралын эсрэг дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй бол эдийн засгийн өсөлт буурч -3.2 хувь болохоор байна. Энэхүү 3.2 хувийн бууралтын гол шалтгаан нь 2008 оны 4 дүгээр улирлаас эхлэн манай улсын гол экспортын бараа, түүхий эдийн үнэ дэлхийн зах зээл дээр буурч улмаар орлого, валютын нөөц багасч, төгрөгийн ам.доллартай харьцах ханш суларсан, банкуудын зээл олголт буурсан зэргээс шалтгаалан бодит салбарын хөгжил удааширч, үйлчилгээний салбарт өсөлт гарахааргүй байна.

Хоёрдугаар хувилбар буюу бодлогын хувилбар: Хандивлагчдын техникийн зөвлөлдөх ээлжит уулзалтаар тохирсон зээл, тусламжийг шуурхай авч эдийн засаг, нийгмийн хөгжилд үр өгөөж, ашигаа өгөх, салбарт оруулах, мөн санхүү, эдийн засгийн хүндрэлийг даван туулах төлөвлөгөөнд тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, ХАА-н салбарт ОХУ-аас олгох 300 сая ам.долларын зээл, зарим орд газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлснээр эдийн засгийн өсөлт 2009 онд 3.1 хувиар өсч, цаашид дунд хугацаанд өсөлтийн хурдац нэмэгдэхээр байна. Мөн энэхүү бодлогын хувилбар нь ОУВС-ын тооцоо, төсөөлөлтэй ойролцоо байна.

Инфляци. Манай улсын хэрэглээний үнийн түвшингийн ерөнхий индексийн өөрчлөлтөнд мах, шатахууны үнэ нилээд нөлөөлдөг бөгөөд 2010-2012 онд дэлхийн эдийн засаг сэргэж гадаад зах зээлд газрын тосны үнэ

Зураг 16. Инфляцийн түвшин




харьцангуй тогтвортой байх төлөвтэй байгаагийн дээр байгаль цаг уурын огцом өөрчлөлт хүндрэл гарахааргүй байна. Дунд хугацаанд “Атрын 3 дахь аян”-ы хэрэгжилт эрчимжиж, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, махны үйлдвэрлэлийг дэмжиж, нөөцийн махны худалдааг оновчтой зохион байгуулах зэрэг бодлогын арга хэмжээний үр дүнд өргөн хэрэглээний барааны үнэ тогтвортой

байж, хэрэглээний үнийн индекс нэг оронтой тоонд байхаар байна.

Валютын ханш. Сүүлийн жилүүдэд үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш харьцангуй тогтвортой байсан хэдий ч экспортын бууралтаас шалтгаалан манай улсын валютын нөөц багассанаас төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2008 оны 4 дүгээр улирлаас эхлэн тасралтгүй суларсан ба харин сүүлийн үед чангарах байдал ажиглагдаж байна. Цаашид ОУВС, хандивлагч орнуудын зээл тусламж орж ирснээр гадаад валютын нөөц нэмэгдэж, улмаар валютын ханш тогтворжих төлөвтэй байна. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өмнөх жилүүдийн тоон мэдээлэл дээр үндэслэн 2010-2012 оны төлвийг төсөөлөхөд нэг ам.доллар 1300 орчим төгрөгтэй тэнцэхээр байна.

Нийт хэрэглээ. ДНБ-д эзлэх хэрэглээний түвшин 2009 онд буурч, 2010-2012 онд тогтвортойгоор өсч 57.1-57.6 хувьд хүрэхээр байна. Гадаад худалдааны ДНБ-д эзлэх хувь багасч байгаатай холбоотойгоор эцсийн хэрэглээний ДНБ-д эзлэх хувь цаашид өсөхөөр байна.

Зураг 17. ДНБ-д эзлэх хэрэглээ, хуримтлалын хэмжээ



Нийт хуримтлал. Нийт хуримтлал нь 2010-2012 онд дунджаар ДНБ-ий 44.6 орчим хувийг эзэлж байна. 2009 онд нийт хуримтлалын хэмжээ буурч байгаа ч цаашид тогтвортойгоор өсөхөөр байна. Тухайлбал, уул уурхайн үйлдвэрлэл эрчимжихтэй уялдаж гаднаас

орж ирэх хөрөнгийн урсгал өсч, нийт хуримтлалыг нэмэгдүүлэхээр байна. Мөн Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, санхүү эдийн засгийн хүндрэлийг даван туулах төлөвлөгөө зэрэгт тусгагдсан дэд бүтэц, үйлдвэрлэлийн бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор хөрөнгө оруулалтын хэмжээ ч эрс нэмэгдэхээр байна.

Гадаад худалдаа. 2010-2012 онд экспортын хэмжээ жилд дунджаар 8.0-27.0 хувиар, импорт 6.1-19.2 хувиар өсөхөөр байгаа бөгөөд гадаад худалдааны тэнцэл 2010 онд 227.3 сая ам.долларын алдагдалтай гарахаар байна. Гадаад худалдааны үзүүлэлтүүдийг дараахь байдлаар төсөөлж байна.


Хүснэгт 3. Гадаад худалдааны үзүүлэлтүүд, 2008-2012

	2008	2009*	2010**	2011**	2012**
Экспорт, сая ам.доллар	2534.5	2204.2	2705.1	3434.6	3709.2
Импорт, сая ам.доллар	3244.6	2764.7	2932.4	3496.6	3794.7
Гадаад худалдааны тэнцэл сая ам.доллар	-710.1	-560.5	-227.3	-62.1	-85.5
Тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	-13.5	-11.6	-4.2	-1.0	-1.2

*-ХБГ, **-төсөөлөл

Төлбөрийн тэнцэл. 2010-2012 онуудад төлбөрийн тэнцэлийн алдагдал буурч ашигтай гарахаар байгаа нь урсгал дансны тэнцэл сайжирч, албан ёсны шилжүүлгийг оролцуулаад 2010 онд 193.5 сая ам.доллар, 2011 онд 40.6 сая ам.доллар, 2012 онд 136.4 сая ам.долларын


Зураг 18. Нийт төлбөрийн тэнцэл, сая ам.доллар



2009 онд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурснаас шалтгаалан төлбөрийн тэнцлийн хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг багасахаар байгаа бол 2010-2012 онуудад харьцангуй тогтвортой байхаар байна. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ бага зэрэг буурах боловч дэлхийн эдийн засгийн байдал 2010 оноос сайжирч эхлэхээр байгаа, мөн манай орны уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ өсөхөөр байгаатай холбоотой. Засгийн газрын гадаад зээлийн хэмжээ 2010 онд 194 сая ам.доллар, 2011 онд 113.9 сая ам.доллар, 2012 онд 82.4 сая ам.доллар байна.

Төсвийн орлого: Төсвийн орлогын ДНБ-д эзлэх хэмжээ ОУВС-тай тохирсон хөтөлбөрийн дагуу 2010 онд 31.6 хувь, харин 2011 онд 28.0 хувь, 2012 онд 27.0 хувьтай байхаар байна. 2010 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2010-2011 оны төсөөллийг боловсруулахдаа улсын төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгож, төсвийн зарлага санхүүжилтийн

Зураг 19. Урсгал дансны тэнцэл, сая ам.доллар



тасралтгүй байдлыг хангахад чиглүүлэх, эдийн засгийн өсөлтийг татварын бодлого, төсвийн хөрөнгө оруулалтыг бодит салбар руу чиглүүлэх зорилтуудыг хангах чиглэлийг баримталлаа.

Цаашид архи, тамхи зэрэг нийгэмд үр ашиг багатай бүтээгдэхүүний онцгой албан татварыг нэмэгдүүлэх, нөгөө талаас татварын ачаалалыг бууруулж, бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа өргөжүүлэн хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэх боломж олгох зэргээр 2012 он хүртэл төсвийн орлогын хэмжээг харьцангуй тогвортой түвшинд байлгахад төсөөлж байна.

Уул уурхайн салбарын нөлөөлөл: стратегийн зарим томоохон ордуудыг 2010 оноос ашиглаж эхлэхээр төлөвлөж, улсын төсөвт уул уурхайн салбараас орох орлогыг нэмж тооцлоо.

Гэхдээ уул уурхайн салбараас төсөвт төвлөрөх орлого нь дэлхийн зах зээл дэх эрдэс баялгийн үнэ, ханшны одоогийн огцом өөрчлөлтөөс шалтгаалж ойрын жилүүдэд ч ихээхэн мэдрэмтгий, тогтворгүй байдалтай байж болзошгүй байгаа тул улсын төсвийн орлогын тогтвортой байдлыг хадгалах үүднээс дэлхийн зах зээл дэх эрдэс баялгийн үнэ, ханшийн эрсдлийг уян хатан тооцож төсвийн орлогын төлөвлөгөөнд тусгахыг зорилоо.

Төсвийн зарлага: Төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хэмжээ 2010 онд 35.6 хувь, 2011 онд 31.0 хувь, 2012 онд 29.0 хувьтай байх хандлагатай байна.

Төсвийн зардлыг 2010-2012 онуудад бууруулж ДНБ-д эзлэх хувийг багасгах бодлого баримтласан.

Хөрөнгийн зардал: 2008-2012 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгасан ажлын байрыг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд хөрөнгийн зардлыг 2010 онд ДНБ-ий 5.8 хувь, 2011 онд 4.5 хувь, 2012 онд 4.7 хувьд хүргэх зорилт тавьж байна. 2010-2012 онд дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр авч байгаа томоохон арга хэмжээнүүд үндсэндээ шийдвэрлэгдэх бөгөөд 2010-2012 онд хөрөнгийн зардлын ДНБ-д эзлэх хэмжээг тогтвортой хадгалахаар тооцлоо.

Төсвийн тэнцэл: Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээг 2010-2012 онд макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангах түвшинд -2 хувь байхаар тооцож байна.

2010-2012 оны Төсвийн хүрээний мэдэгдлийн төсвийн үзүүлэлтүүдийг 2008-2010 оныхтой харьцуулбал:

	Үндсэн үзүүлэлтүүд	2008-2010 оны ТХМ			2010-2012 оны ТХМ		
		2008 он	2009 он	2010 он	2010 он	2011 он	2012 он
	ДНБ-д эзлэх хувиар						
1	Хөрөнгийн зардлын хэмжээ	7.8	7.8	7.8	5.8	4.5	4.7
2	Төсвийн алдагдлын хэмжээ	-3.0	-3.0	-3.0	-4.0	-3.0	-2.0

Засаглал хоорондын төсвийн харилцаа: Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн үр дүнг хангах хариуцлагын тогтолцоог бүх түвшинд сайжруулах зорилт тавьж байна. Орон нутгийн төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлж, төсвийн зарцуулалт, санхүүжилтийн үр дүнг сайжруулахад онцлон ахнаарна. Орон нутагт улсын төсвөөс хувиарлах төсвийн хэмжээг түүний санхүүжилтийн үр дүнтэй нь холбон дунд хугацаанд хэвээр хадгалах чиглэл баримтална.

**САНГИЙН
ЯАМ**

**ҮНДЭСНИЙ ХӨГЖИЛ,
ШИНЭТГЭЛИЙН ХОРОО**